



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/369

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 17 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" бүлгийн 3.1.3.2 дахь заалт, Цахим-Алтай хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагуудын архивын хөмрөгийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, цаасан суурьтай баримтаас цахим архивын баримтыг үүсгэх, архивын үйл ажиллагааг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж худалдан авах зардалд хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах 9,697,800 (есөн сая зургаан зуун ерэн долоон мянга найман зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүйн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

